

## **Монгол Улстай хамтран ажиллах нь ОХУ-ын аюулгүй байдлыг хангах чухал ЧИГЛЭЛ МӨН**

**Михаил Винокуров\***

ОХУ-ын эсрэг барууны орнуудын авсан эдийн засгийн хоригийн хариуд манай засгийн газар хариу арга хэмжээ авснаар гурав орчим долоо хоног өнгөрлөө. Иймээс одоо зарим нэг дүгнэлт хийж, түүний үндсэн дээр залруулах үйл ажиллагаа явуулах боломжтой гэж бодож байна.

ОХУ-ын уг хариу үйлдлүүд нь зүйд нийцсэн, орчин үед тохирсон, уялдаа холбоотой арга хэмжээнүүд мөн гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Барууны орнуудад дэлхий харилцан уялдаатай, санкци гэдэг зүйлээр тоглох нь хоёр үзүүртэй зэвсгээр тоглохтой адил гэдгийг ойлгуулж чадсан болов уу.

Барууны орнуудын засгийн газрууд өөрсдийгөө дөвийлгөн гайхуулахдаа Оросын авах боломжит хариу үйлдийн талаар огтхон ч бодоогүй. Тиймээс шангаа хүртсэн гэж бодож байна. Түүгээр ч барахгүй, хэрэв цаашид бидний эсрэг авах хориг арга хэмжээний тоо нэмэгдэж, тэдгээрийн үйлчлэх хугацаа уртасвал, бид ч мөн адил арга хэмжээ авч чадна гэдгийг тод томруун ойлгуулах ёстой.

Жишээ нь, бид ой модны бүтээгдэхүүнээ бүхлээр нь гаргахаа огцом багасгаж, ой модны боловсруулалтын бүтээгдэхүүний үнийг үлэмж нэмэгдүүлэх боломжтой. Энэ нь бидэнд илүү ашигтайгаас

---

\* Ар Байгалийн эдийн засаг, эрх зүйн Их сургуулийн ректор Эдийн засгийн ухааны доктор, профессор

гадна ой модны нэгжийн (одоогийн хөдөө аж ахуйтай адил) байдлыг эрс өөрчлөх боломж олгоод зогсохгүй түүний үр ашиг болон орлогыг дээшлүүлж, дотоодын боловсруулалт, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжтой болно. Одоогийн байдлаар биднийг Дэлхийн худалдааны байгууллагын /ДХБ/ хориг арга хэмжээгээр сүрдүүлэн модыг бүхлээр нь гаргахаас өөр аргагүй байдалд орууллаа.

ДХБ-ын тухайд....Бидний үзэж буйгаар, хэрэв хориг арга хэмжээний дайн цаашид үргэлжилбэл, бид ДХБ-ын гишүүнчлэлээс татгалзах эрхтэй. Эдгээр хориг арга хэмжээгээр ДХБ-ын мөн чанар үгүй болж, харин бидний энэ байгууллагын гишүүн байх үгүй гэсэн асуудал Оросын хувьд нэмэх биш, харин хасах шинжтэй болно. Өөрийн авч буй хориг арга хэмжээнүүдээр барууны орнууд ДХБ-ыг шударга ажлын төлөө биш, харин хоёрдмол стандартын төлөө ашиглаж байгааг нотолсон хэрэг боллоо.

Өөр нэг үр ашигтай арга хэмжээ бол тансаг хэрэглээ болон үнэтэй тээврийн хэрэгсэл (автомашин) оруулж ирэхийг хязгаарлах явдал юм. Бид одоогийн байдлаар Европт үйлдвэрлэгэж буй, үүнд Герман, Англи, Франц, түүнчлэн Японы, үнэтэй машины худалдан авагчдын нэг мөн. Энэ үргэлжилж буй айлган сүрдүүлэлтийн явцад бид Mercedes, Land Cruiser, Land Rover гэх мэт үнэтэй машинуудгүй амьдарч чадна гэдэгт эргэлзэхгүй байна. Тэгснээр тэд маш эмзэг, одоогийн байдлаар хэт үйлдвэрлэлийн бүх шинжийг агуулж буй салбарын нэг болох машин үйлдвэрлэлтийн салбарт томоохон цохилт авах нь дамжиггүй.

Тоочих нь илүүц биз. Харин энгийн нэг зүйлийг тодотгож хэлмээр байна: худалдааны дайн харилцан ашиггүй зүйл юм. Тиймээс бид харилцан хориг арга хэмжээ авахаас татгалзахыг уриалж байна.

Гэвч эдгээр хориг арга хэмжээ авагдсанаар бидний дасал болж, анхаарахаа болисон сөрөг зүйлүүд ил боллоо. Үүгээр Гайдарын: “Бүхнийг худалдан авна” гэдэг уриа худал гэдэг нь нотлогдов. Үнэндээ бид зөвхөн түүхий эдээ (газрын тос, хий) зарж л худалдан авалт хийдэг. Ингэснээр өөрийн үйлдвэрлэлээ ч бут цохисон юм. Одоо бид зөвхөн машин бус, өргөст хэмх, ихэнхи жимс, мах, сүү зэрэг бүтээгдэхүүнийг худалдан авч байна. Үүнд хаанаас юу авч байна вэ гэвэл: Германаас

## ГАДААДЫН ЭРДЭМТЭД МОНГОЛЫН ТУХАЙ

даршилсан өргөст хэмх, Польшоос алим, Израилаас хонины мах, Бельгис жигнэмэг гэх мэтчилэн. Сүүлдээ хүнсний 40% хүртэлхи хувийг гаднаас оруулж ирэхдээ туллаа. Энэ нь маш аюултай. Энэ нь хүнсний аюулгүй байдлыг бүрэн алдагдуулахад хүргэнэ. Үүнийг бүгд ойлгосон, тэд ч мөн адил.

Японы жишээг энд дурдмаар байна, Дэлхийн хоёрдугаар дайны дараа хүнсний аюулгүй байдлын талаар зохих дүгнэлт хийсний үндсэн дээр одоогийн байдлаар, жишээ нь вьетнамыхаас хэд дахин үнэтэй ч, цагаан будааны хэрэгцээгээ 100% өөрсдөө хангаж байна

Бид хүнсээ оросын үйлдвэрлэгчдээс хэд дахин өндөр цалинтай, өөрийн өртөг маш өндөр байдаг Европоос худалдан авч байна. Европын бүтээгдэхүүнүүд (тэдгээрийн үнэ) Европын холбооноос хөдөө аж ахуйд үзүүлж буй ихээхэн хэмжээний татаас дээр тогтож манай бүтээгдэхүүнийг манай зах зээлээс шахан гаргахад хүрч байна. Оросын сүлжээний дэлгүүрүүд дан барууны бараагаар дүүрсэн. Ингэхдээ бид газрын тос, хий болон бусад түүхий эдээ зарж олсон валютаар эдгээрийг худалдан авч байгаа. Уг нь бид өндөр зэрэглэлийн боловсруулалттай бүтээгдэхүүнээ зарж эргээд түүхий эд авбал зүгээр юм. Жинхэнэ хэрэг дээрээ бид маш буруу эдийн засгийн нөхцөлтэй тулгарлаа: түүхий эдээ “шавхаж”, хүнсний бүтээгдэхүүн худалдаж худалдан авч байна. Ийм байдлаар хол явахгүй нь тодорхой. Үнэндээ бид “түүхий эдийн” гүрэн болох нөхцөл рүү аажмаар орж байна. Эдгээр хориг арга хэмжээ биднийг сэрээж, энэ байдал ямар утгагүй болохыг харууллаа гэж бодож байна. Иймээс маш шуурхай дүгнэлт хийх шаардлагатай.

Нэгдүгээрт, дотоодын хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлээ хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Орос өөрийн нөөцдөө тулгуурлан зөвхөн өөрийгөө бус, бусдыг ч хооллох боломжтой (жишээ нь Финлянд). Үүний тулд хөдөө аж ахуйг хөгжүүлэх цаг хугацааг зөв тооцсон, хөрөнгө зарцуулсан, хөнгөлттэй зээл дэмжлэгтэй тодорхой хөтөлбөр шаардлагатай болно. Тиймээс ийм хөтөлбөрийг Төрийн Думаар батлуулах нь зүйтэй юм.

Хоёрдугаарт, Орост орж ирж буй хүнсний болон хөдөө аж ахуйн

ОЛОН УЛС СУДЛАЛ

бүтээгдэхүүн нийлүүлэгч нарын тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Ингэхдээ манайхаас тодорхой хэмжээний аж үйлдвэрийн болон бусад бүтээгдэхүүн худалдан авдаг орнуудыг сонгох хэрэгтэй, гэтэл одоогоор улсын эрх ашгийг умартан ашиг сонирхлоо нэгдүгээрт тавьсаар байна.

Гуравдугаарт, хүнс нийлүүлэгч нарыг сонгохдоо хамгийн бага өртөгтэйг сонгох.

Дөрөвдүгээрт, экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй газрыг сонгох нь зүйд нийцнэ.

Энд хүрээд бид Оросын хувьд чухал болоод байгаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болох мах болон буудайн худалдан авалтын асуудалд хүрлээ. Эдгээр үзүүлэлт ОХУ-ын 1990 оны байдлыг харуулна: (хүснэгт. 1,2).

*Хүснэгт №1. ОХУ-д мах болон буудайн үйлдвэрлэл 1990 онд, мян. тонн*

Бүтээгдэхүүн	Үйлдвэрлэл	Экспорт	Импорт	Хэрэглээ
Буудай	107,0	-	29,0	136,0
Үүнд:				
Улаан буудай	46,2	-	17,6	63,8
Цагаан будаа	0,8	-	0,5	1,3
Шош	2,5	-	-	2,5
Эрдэнэ шиш	2,1	-	5,5	7,6
Мах	8,26	-	3,6	11,8
Үүнд:				
Үхрийн мах	3,6	-	1,28	4,8
Гахайн мах	2,8	-	1,3	4,1
Хонины мах	0,3	-	0,4	0,8
Шувууны мах	1,4	-	0,7	2,1

ГАДААДЫН ЭРДЭМТЭД МОНГОЛЫН ТУХАЙ

Хүснэгт №2. ОХУ-ын буудай болон махны үйлдвэрлэл 2013 онд.  
мянган тонн

Бүтээгдэхүүн	Үйлдвэрлэл	Экспорт	Импорт	Хэрэглээ
Буудай, нийт	92,4	19,3	-	73,1
Үүнд:				
Улаан буудай	52,1	14,2	-	34,9
Цагаан будаа	0,9	-	-	0,9
Шош	1,6	-	-	1,6
Эрдэнэ шиш	11,8	2,8	-	9,0
Мах, нийт	8,3	0,1	2,4	10,7
Үүнд:				
Үхрийн мах	1,65	-	0,7	2,34
Гахайн мах	2,8	-	0,9	3,7
Хонины мах	0,05	-	0,5	0,6
Шувууны мах	3,8	-	0,3	4,1

2013 он гэхэд буудайны асуудал бүрэн шийдэгдсэн (Орос буудайн экспортоо нэмэгдүүлж байна). Харин мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл хүндрэлтэй хэвээр байна. Шувууны махаар өөрийн зах зээлээ 95-96%-р хангаж байна. Гахайн махны хувьд бүрэн хангах хэмжээнд хүрч ойрын 2-3 жилийн дотор өөрийн тоо толгойгоор хангах боломжтой боллоо (үүнд халдварт өвчин саад болж үүнээс үүдэлтэйгээр гахайн тоо толгой үлэмж хэмжээгээр хорогдож буй). Харин үхэр болон хонины махны асуудал хүндрэлтэй тулгарч байна. Бид дотоодын үйлдвэрлэлийн зөвхөн 70%-г хангаж бусдыг нь гаднаас оруулж ирдэг. (хүснэгт 3)

ОХУ-ын мах нийлүүлэгч орнууд:

Улс	Махны хувийн жин,%
Латин Америкийн орнууд	44
Европын холбооны орнууд	25
Англи хэлтэн орнууд (АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд)	13
Бусад	18

## ОЛОН УЛС СУДЛАЛ

Үүнээс үзэхэд махны үндсэн нийлүүлэгч бол Латин Америк бөгөөд Европын Холбоо, англи хэлтэн орнуудаас мах оруулахыг хориглосноос хойш бид Бразил болон Аргентинаас махны экспортоо нэмэгдүүлэх шаардлагатай боллоо.

Үүнээс импортын махны 70 орчим хувь Москва болон Санкт-Петербург хотуудад ноогддог.

Монгол улс бүх үзүүлэлтээр махны хамгийн ашигтай нийлүүлэгч мөн бөгөөд монголын үхэр, хонины мах үйлдвэрлэгчдийг оросын зах зээлд татан оруулахыг идэвхитэй уриалж байна.

*Монгол мах юугаараа давуу талтай вэ?*

Нэгдүгээрт, өөрийн өртөг болон ОХУ-ын хувьд хамгийн доод үнэ. Монголд 1 кг үхрийн мах 146, хонины мах 129 рубль байдаг. Энэ нь оросын зах зээлийн үнээс 2 дахин хямд гэсэн үг.

Хоёрдугаарт, Сибирьт хэд хэдэн махкомбинат байгуулагдсан: Эрхүү, Улаан-Үд, Чита зэрэг хотуудад. Эдгээр үйлдвэрүүд цэрэг армийн зориулалттай махан бүтээгдэхүүний ихэнхи хувийг үйлдвэрлэж байна. Тээвэрлэлтийн өртөг хямд байгаа нь борлуулалтын үнэд зэрэг нөлөөлж буй нь Сибирь болон Алс Дорнодын бүс нутгийн хувьд маш чухал зүйл юм.

Гуравдугаарт, Монгол бидэнд махаа амьдын жингээр зарах цорын ганц орон. Өөрөөр хэлбэл, бид малыг төмөр зам, авто тээврээр махны үйлдвэрүүддээ шууд хүргэх боломжтой. Энэ бидэнд юу өгөх вэ? Ингэснээр бид хөргөсөн мах үйлдвэрлэж бүх орон даяар, тухайлбал Сибирьт, махаа шинээр нь борлуулах боломжтой болсон. Харин Бразил Аргентинаас бид зөвхөн хөлдөөсөн мах авч байна. Өөрөөр хэлбэл, Монголын ачаар бид сайн чанарын шинэ мах хэрэглэх боломжтой болно.

Дөрөвдүгээрт, Монголчууд малаа хээрийн бэлчээрт малладаг учраас экологийн цэвэр, ямар ч концентрат, био нэмэлт, антибиотик зэрэг химийн найрлагагүй байна.

Тавдугаарт, бид Монголоос мах нийлүүлэхдээ буцаагаад барилга, машин үйлдвэрлэл, химийн зэрэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн

## ГАДААДЫН ЭРДЭМТЭД МОНГОЛЫН ТУХАЙ

экспортлох боломжтой юм. Энэ нь маш ашигтай төдийгүй хоёр улсын худалдааны харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүчин зүйл юм.

Түүнчлэн хуучнаар Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн гишүүн орнуудаас ЗХУ-ыг задран унасны дараа Оростой найрсаг харилцаатай үлдсэн улс бол Монгол. Мах, махан бүтээгдэхүүнээс гадна бид Монголоос ноос авч, Оросын үйлдвэрүүдэд боловсруулах зэрэг олон чиглэлээр хамтран ажиллах боломжтой.

Эцэст нь, геополитикийн асуудал. Орос Монгол дахь байр сууриа алдсан нь нууц биш. Монголын экспортын нийт хэмжээг Хятад 86.8%-р тэргүүлж байгаа бол араас нь Их Британи 4,7%, Канад 3.2%, бусад орнууд- 5,3% (тухайлбал ОХУ 1,5%) эзэлж байна. Монголд орос хэл сургуулийн хичээлийн хөтөлбөрөөс бүрэн хасагдаж, улс төрийн холбоо түр зуурын шинжтэй гэх мэт олон зүйл байна. Гэтэл энэ зуур Хятад, АНУ, Япон, Өмнөд Солонгос зэрэг орнууд тийшээ идэвхитэй нь аргагүй “шургасаар” байна. Энэ улс төв азид манай “бөөрөн” доор 3,5 мянган км урт хилтэй, 1,5 сая км<sup>2</sup> газар нутагтай, ашигт малтмалын бараг бүх баялагтай, маш ашигтай стратегийн байршлал эзэлдэг улс. Түүгээр үл барам, маш эрчимтэй хөгжиж буй улс. Монголын ДНБ хэдэн жил дараалан 10% хол давсаар байна. Дэлхийн эдийн засгийн хамгийн хурдацтай хөгжиж буй 5 орны тоонд зүй ёсоор багтаж буй гээд олон хүчин зүйлсийг тоочиж болно.

Тиймээс манай улсын Ерөнхийлөгч В.Путинд Монголд хийх айлчлалынхаа үеэр яриа хэлэлцээрээ амжилттай хийж, энэхүү нийтлэлд дурьдсан асуудлуудыг хөндөөсэй гэж хүсч байна.

Эх сурвалж: [www.argumenti.ru/society/n451/359962](http://www.argumenti.ru/society/n451/359962)

*Орчуулсан э/ш ажилтан Ж.Орхон*